

ТАНИЛЦУУЛГА

“Хууль сахиулах үйл ажиллагааны тухай” хуулийн төслийн тухай

Өнөөгийн байдлаар манай улсад хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэгч субъектууд болон тэдний эрх, үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээ хүрээг зохицуулсан 10 гаруй хууль байна.

Энэ байдал нь хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг бий болгож, улмаар ижил төрлийн хууль сахиулах үйл ажиллагааг харилцан адилгүй үндэслэл, журмаар хэрэгжүүлэх, ялангуяа үйлдсэн зөрчлийг шалган шийдвэрлэх нэрийн дор хуулийг бус Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга болон бусад субъектүүдээс баталсан эрх зүйн актуудыг үндэслэн хүний эрхэд халдах, халдашгүй эрхийг нь хязгаарлах зэргээр хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхагдахгүй байх, хүний эрхэд зөвхөн хуулиар хязгаарлалт тогтоох Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрхийг хангах явдал гажуудах нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд дээрх асуудлуудыг шийдвэрлэх, зохицуулах зайлшгүй шаардлагыг харгалзан үзэж, зөрчил, гэмт хэргийг шалган тогтоох ажиллагааны явцад хүний халдашгүй эрхийг хангах, хууль сахиулагчийн хэрэгжүүлэх эрх хэмжээг нэг стандартад оруулж, тодорхой хуульчлах зорилгоор Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид заасан суурь зарчимд нийцүүлэн Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төсөл боловсруулах ажлыг шүүх, прокурор, өмгөөлөл, хууль сахиулах байгууллага, холбогдох ТББ, судлаачдаас бүрдсэн Ажлын хэсэг гүйцэтгэсэн болно.

Төслийг боловсруулахад Хууль зүй, дотоод хэргийн яам болон төрийн болон төрийн бус бусад байгууллага, судлаачдаас энэ чиглэлээр хийсэн судалгаа, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, НҮБ-аас боловсруулсан Эрүүгийн процессын загвар хууль болон хэрэг хянан шийдвэрлэх процессийн ажиллагаанд хүний эрхийг хангах чиглэлээр тэргүүлэх туршлага бүхий Канад, Австрали, БНСУ, Япон зэрэг улсуудын хууль, НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн Зөвлөмжийг ашигласан болно.

Нэг.Хуулийн төслийн бүтцийн талаар:

Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн зорилт нь нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор явуулах хууль сахиулах ажиллагааны үндэслэл, журмыг тогтоох, энэхүү ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад чиглэгдэнэ.

Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөл нь 6 бүлэг, 47 зүйлтэй бөгөөд дараахь бүтэцтэй байна:

I бүлэг: Нийтлэг үндэслэл

II бүлэг: Хууль сахиулах нийтлэг ажиллагаа

III бүлэг: Хууль сахиулах нийтлэг ажиллагаа

IV бүлэг: Нийтийн хэв журам сахиулах

V бүлэг: Албадлага хэрэглэх

VI бүлэг: Хууль хүчин төгөлдөр болох

Хоёр.Хуулийн төсөлд туссан голлох өөрчлөлтийн талаар:

1.Хууль сахиулах нэрийн дор хяналтгүйгээр хүний эрхийг хязгаарладаг явдлыг хална.

Хууль сахиулах ажиллагаа ажиллагаа буюу нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор явуулах тодорхой ажиллагааны үед хууль сахиулагчийн эдлэх эрх, хүлээх үүргийг нарийвчлан зохицуулах шаардлагын хүрээнд холбогдох зохицуулалтыг тусгалаа.

Өөрөөр хэлбэл хууль сахиулагч хүн, тээврийн хэрэгслийг зогсоон шалгах, хүн, хуулийн этгээдийн бичиг баримт, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, хүн, жолоочийн мансуурсан, согтуурсан эсэхийг шалгах, тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, тодорхой үүрэг гүйцэтгэх зорилгоор бусдын орон байран, эзэмшил газарт нэвтрэн орох зэрэг ажиллагаа явуулах үндэслэл, журмыг нэгдсэн байдлаар хуульчлахаар заалаа.

2.Онцлог нөхцөл байдал, дэглэм тогтоосон үед нийтийн хэв журам сахиулах ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл, журмыг хуулиар тогтооно.

Нийгмийн хэв журам сахиулах зорилгоор хорио цээрийн дэглэм сахиулах, нийгмийн эмх замбараагүй байдлын болон жагсаал, цуглааныг албадан тараах үед хууль сахиулагчийн хэрэгжүүлэх тодорхой ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх журмыг хуулиар бус тухайн байгууллагын даргаас баталсан эрх зүйн актаар зохицуулж байсныг өөрчлөн хүний эрхийн стандартад нийцүүлэхийн зэрэгцээ иргэдэд нээлттэй болгох зохицуулалтыг тусгалаа.

3.Гүйцэтгэх ажлын арга, хэрэгслээр цуглуулсан баримт мэдээллийг нотлох баримтад тооцохгүй байгааг өөрчилнө:

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар “гүйцэтгэх ажлын хавтаст хэрэг” тусгайлан нээж, нууц ажиллагааг Гүйцэтгэх ажлын тухай хууль, болон тусгай журмаар хэрэгжүүлэх, хүний эрхэнд зөвшөөрөлгүй халдах явдал хууль сахиулагчийн үзэмжээр шийдэгдэж байсныг өөрчлөх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

4.Албадлага хэрэглэх журмыг нарийвчлан тогтооно:

Хууль сахиулагчид хүний эрхийг хязгаарлах тэр дундаа хүч, албадлага хэрэглэх онцгой эрхтэй байдаг.

Хуулийн төсөлд хууль сахиулагчаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэл, журмыг НҮБ-ын хүний эрхийн стандартад хууль сахиулагч хүчийг гарцаагүй нөхцөлд эцсийн арга болгон тохирсон хэм хэмжээнд бүрэн хяналтын дор хэрэглэх¹, ийнхүү хэрэглэхдээ давших бус хамгаалах аргад суурилах зарчмыг баримтална гэснийг удирдлага болгон шинэчлэн зохицууллаа.

Галт зэвсгийг хэрэглэх эрхийг хуулиар олгогдсон боловч тусгай сургалтанд хамрагдаж, шалгуур хангаагүй тохиолдолд хэрэглэх эрх нээгдэхгүй байхаар зохицуулж, галт зэвсэг хэрэглэх сургалт зохион байгуулах, галт зэвсэг хэрэглэх эрх олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгалаа.

Гурав.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байдал:

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхлэх Эрүүгийн хуультай, түүнчлэн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдаж байгаа Цагдаагийн албаны тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлтэй тус тус уялдуулан боловсруулсан.

Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөлтэй уялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай Байгаль орчныг хамгаалах тухай, Гаалийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай, Жагсаал, цуглаан албадан тараах журмын тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих журмын тухай, Гүйцэтгэх ажлын тухай, Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай болон Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

-----ooOoo-----

¹ Хууль сахиулагчийн зан үйлийн дүрэм - Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны 34/169А тоот тогтоол.

Нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий албан тушаалтан галт зэвсэг болон хүч хэрэглэх үндсэн зарчим.НҮБ-ын 8-р Их хурал.